

**ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ ДЭРГЭДЭХ ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ  
ХӨГЖЛИЙН ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2018 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр

№03

Засгийн газрын 8 дугаар байр  
Олимпийн гудамж – 2  
Сүхбаатар дүүрэг 14120  
Монгол Улс  
Утас: 264269

Төгсөлтийн дараах үндсэн ба төрөлжсөн мэргэшлийн  
сургалтын хөтөлбөр зөвшөөрөх тухай

Монгол Улсын Эрүүл мэндийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.13, 25.14 дах хэсэг, “Мэргэшүүлэх болон тасралтгүй сургалт зохион байгуулах, сургалт эрхлэх байгууллагыг сонгох, зөвшөөрөл олгох, сунгах, хүчингүй болгох журам”-ын 3.2.3.1, 3.2.5, 3.5 дах заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Дараах 9 байгууллагын үндсэн мэргэшлийн сургалтын 10, 4 байгууллагын төрөлжсөн мэргэшлийн сургалтын 4 хөтөлбөрийг тус тус зөвшөөрсүгэй.

№	Сургалт эрхлэх байгууллага	Мэргэшүүлэх хөтөлбөрийн чиглэл
<b>Нэг. Үндсэн мэргэшлийн сургалтын хөтөлбөр</b>		
1.	Улсын нэгдүгээр төв эмнэлэг	1. Нүүр амны мэс засал судлал
2.	Улсын хоёрдугаар төв эмнэлэг	1. Мэдрэл судлал
3.	Улсын гуравдугаар төв эмнэлэг	1. Чих, хамар, хоолой судлал
4.	Нийслэлийн Амгалан амаржих газар	1. Эх барих, эмэгтэйчүүд судлал
5.	Нийслэлийн Хүрээ амаржих газар	1. Эх барих, эмэгтэйчүүд судлал
6.	Цэргийн төв эмнэлэг	1. Мэдээгүйжүүлэг судлал
7.	Уламжлалт анагаах ухаан, технологийн хүрээлэн	1. Монголын уламжлалт анагаах ухаан судлал 2. Зүү эмчилгээ судлал
8.	ЭМЖЖ эмнэлэг	1. Чих, хамар, хоолой судлал
9.	Оточ манрамба их сургууль	1. Монголын уламжлалт анагаах ухаан судлал
<b>Хоёр. Төрөлжсөн мэргэшлийн сургалтын хөтөлбөр</b>		
10.	Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв	1. Эх ураг судлал
11.	Хавдар судлалын үндэсний төв	1. Толгой, хүзүүний мэс засал судлал

12.	Цэргийн төв эмнэлэг	1. Эмнэл зүйн хордого судлал
13.	Халдварт өвчин судлалын үндэсний төв	1. Талбарын тархвар судлал

2. Дээрх үндсэн мэргэшлийн сургалтын 10, төрөлжсөн мэргэшлийн сургалтын 4 хөтөлбөрийн төлөвлөгөөг 2020 оны 1 дүгээр улиралд багтаан Эрүүл мэндийн хөгжлийн төвд хүргүүлж баталгаажуулах, мэргэшүүлэх сургалтын үйл ажиллагаанд нэвтрүүлж, хяналт тавьж ажиллахыг Улсын нэгдүгээр төв эмнэлэг /Т.Мөнхсайхан/, Улсын хоёрдугаар төв эмнэлэг /С.Энхболд/, Улсын гуравдугаар төв эмнэлэг /Ц.Төмөр-Очир/, Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв /Ш.Энхтөр/, Хавдар судлалын үндэсний төв /Н.Эрдэнэхүү/, Халдварт өвчин судлалын үндэсний төв /Д.Нямхүү/, Цэргийн төв эмнэлэг /С.Батболд/, Амгалан амаржих газар /Ц.Батболд/, Хүрээ амаржих газар /А.Жаргал/, Уламжлалт анагаах ухаан, технологийн хүрээлэн /Ч.Чимэдрагчаа/, ЭМЖЖ эмнэлэг /Э.Жаргалхүү/, Оточ манрамба их сургууль /Г.Одонцэцэг/-д тус тус үүрэг болгосугай.

3. “Эмчилгээний гоо сайхан, арьсны мэс засал судлал” төрөлжсөн мэргэшлийн сургалтын чиглэлийг “Арьсны мэс засал судлал” болгож өөрчлөх талаар судалж шийдвэрлүүлэхийг Зөвлөлийн нарийн бичгийн дарга /Д.Баярмаа/-д, Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвөөс боловсруулсан “Эх ураг судлал” төрөлжсөн мэргэшлийн сургалтын хөтөлбөрийг журамд нийцүүлэн 1 жилийн хугацаатай болгож баталгаажуулахыг Эрүүл мэндийн хөгжлийн төв /Б.Нарантуяа/-д тус тус даалгасугай.

4. Тогтоолын дагуу үндсэн мэргэшлийн сургалтын 10, төрөлжсөн мэргэшлийн сургалтын 4 хөтөлбөрийн төлөвлөгөөг баталж, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөний биелэлтэд явцын хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн хөгжлийн төв /Б.Нарантуяа/-д үүрэг болгосугай.

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН  
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ,  
ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ ХӨГЖЛИЙН  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА Я.АМАРЖАРГАЛ

